

Агуулга

ХУРААНГҮЙ ҮГИЙН ЖАГСААЛТ	2
I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
II. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	3
III. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ.....	9
IV. ХАВСРАЛТ	28
V. АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....	42

ХУРААНГҮЙ ҮГИЙН ЖАГСААЛТ

ДЭМБ- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДОХ-Дархлалын олдмол хомсдол

ӨОУА-Өвчний олон улсын ангилал

ҮСХ-Үндэсний статистикийн хороо

ХДХВ-Хүний дархлал, хомсдлын вирус

ШХБХЭ- Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ

ЭМСҮТ-Эрүүл мэндийн статистикийн үндэсний төв

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. “Статистикийн тухай” Монгол улсын хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүн ам, нийгмийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн хүрээг тодорхойлсон уг хуулийн дээрх хэсгийн 3/-д хүн амын эрүүл мэнд, эмнэлэг, эмч, өвчлөгчдийн тоо гэсэн үзүүлэлтүүдийг тусгаж өгсөн.
2. Монгол Улсын эрүүл мэндийн статистикийн үндсэн үзүүлэлтүүд нь Монгол Улсын болон олон улсын түвшинд - хүн амын эрүүл мэндийн бодлогыг тодорхойлох, дун шинжилгээ хийх чухал хэрэгсэл болно.
3. Монгол Улсын эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтүүдийг олон улсын нийтлэг арга зүйд нийцүүлж, статистикийн мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж, ашигладаг бүх шатны байгууллагууд болон ажилтнууд, хэрэглэгчдийг нэгдсэн ойлголт, тодорхойлолт, арга зүй, аргачлалаар хангах, үйл ажиллагаанд нь нэвтрүүлэхэд оршино.

II. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

❖ **“Эрүүл мэнд” гэж хүн өвчин эмгэггүй байх төдийгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ.**

1. **Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/:** Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох, төрсний дараахь 28 хоногийн дотор эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. Нярай хүүхдэд 0-28 хоногтой хүүхдийг хамруулна³.
2. **Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/:** Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох, нэг хүртэлх насандаа /0-364 хоногтой/ эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. Нэг хүртэлх насны хүүхдэд 0-11 сар 28 хоногтой хүүхдийг хамруулна³ (*Амьгүй төрөлт болон зулбалтыг оруулахгүй*).
3. **Амьд төрөлт:** Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг нь салгасан эсэхийг нь харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно⁴.
4. **Амьгүй төрөлт:** Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойшхи хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ³.
5. **Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/:** Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. 5 хүртэлх насны хүүхдэд 0 наснаас 4 нас 364 хоногтой хүүхдийг хамруулна³.
6. **Эхийн эндэгдлийн харьцаа /100 000 амьд төрөлт тутамд/:** Амьд төрсөн 100 000 хүүхдэд ногдох жирэмсэн буюу жирэмсний дараах, мөн хүүхэд төрүүлэх үеийн хүндрэлээс хамаарч нас барсан эхчүүдийн тоог илэрхийлнэ. Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эх эндэхийг эхийн эндэгдэл гэнэ⁴.

7. **Эхийн эндэгдлийн түвшин:** Тухайн жилд 15-49 насны (төрөх насны) эмэгтэйчүүдэд ногдох эндсэн эхийн тоог илэрхийлнэ¹⁰.
8. **Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдах хувь:** Заавал хийх дархлаажуулалтанд, 5-тын вакцин, БЦЖ, халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран (СХТ), В вируст гепатит улаан бурхны эсрэг вакцинжуулалт хамаарна. Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдвал зохих 1 хүртэлх насны хүүхдүүдээс заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ. /Эрүүл мэндийн тухай хуулийн 10-р зүйлд зааснаар/
9. **Зөвхөн хөхөөр хооллодог, 0-6 сартай хүүхдийн эзлэх хувь:** 0-6 сартай хүүхдүүдээс витамин, бичил элементийн нэмэлт тэжээл буюу эм бүхий шингэн бэлдмэлээс бусад нэмэлт хоол, тэжээлийг авахгүйгээр зөвхөн эхийн буюу донорын сүүгээр хооллосон хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ³.
10. **Нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь:** Нэг хүртэлх насны хүүхдийн дунд нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ³.
11. **Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувь:** Нэг хүртлэх насны хүүхэдтэй нийт эмэгтэйчүүдийн дунд хүүхдээ хөхөөрөө хооллож байгаа эхчүүдийн эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь жирэмслэх эрсдэлтэй байгаа эмэгтэйчүүдийн тоог тодорхойлоход ач холбогдолтой юм⁶.
12. **Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь:** Тав хүртэлх насны хүүхдийн тухайн насанд байвал зохих биеийн жин нь АНУ-ын ЭМСҮТ/ДЭМБ-аас боловсруулсан олон улсын стандарт жингийн голчоос 2(3) стандарт хазайлтаар доогуур байгаа 5 хүртэлх насны хүүхдийн энэ насны нийт хүүхдийн дунд эзлэх хувь, хэмжээ болно. Тав хүртэлх насны хүүхдийн тухайн насанд байвал зохих биеийн жин нь АНУ-ын ЭМСҮТ/ ДЭМБ-аас боловсруулсан стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал дунд хэлбэрийн тураалтай, хэрэв 3 стандарт хазайлтаар доогуур бол хүнд хэлбэрийн тураалтай гэж үзнэ³.
13. **Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь:** Тав хүртэлх насны хүүхдийн тухайн насанд байвал зохих биеийн өндөр нь АНУ-ын ЭМСҮТ/ДЭМБ-аас боловсруулсан олон улсын стандарт өндрийн голчоос 2(3) стандарт хазайлтаар доогуур байгаа 5 хүртэлх насны хүүхдийн энэ насны нийт хүүхдийн дунд эзлэх хувь болно. Өсөлтийн хоцролттой: 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насанд байвал зохих биеийн өндөр нь АНУ-ын ЭМСҮТ/ ДЭМБ-аас боловсруулсан стандарт өндрийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал дунд хэлбэрийн хоцролттой, хэрэв 3 стандарт хазайлтаар доогуур бол хүнд хэлбэрийн хоцролттой гэнэ³.
14. **Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь:** Тав хүртэлх насны нийт хүн амын дунд тухайн насны хүүхдийн биеийн өндөрт зохицох биеийн жин нь АНУ-ын ЭМСҮТ/ДЭМБ-аас боловсруулсан олон улсын стандарт жингийн голчоос 2 (3) стандарт хазайлтаар доогуур байгаа 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь, хэмжээ болно. Тав хүртэлх насны хүүхдийн тухайн биеийн өндөрт зохицох биеийн жин нь АНУ-ын ЭМСҮТ/ ДЭМБ-аас боловсруулсан стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур байвал дунд хэлбэрийн туранхай, хэрэв 3 стандарт хазайлтаар доогуур бол хүнд хэлбэрийн туранхай гэнэ³.
15. **Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент:** Тухайн жилийн өсвөр насны 1000 охидод ногдох бүртгэгдсэн өсвөр насны жирэмсэн охидын тоог илэрхийлнэ. **Өсвөр үе:** 10-19 насны хүүхэд, залуучуудыг хамруулна⁶.

- 16. Өсвөр насны охидын жирэмслэлтийн хувь:** Тухайн жилийн нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд өсвөр насны жирэмсэн охидын эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ⁶.
- 17. Жирэмсний хяналтын хувь:** Тухайн жилийн нийт жирэмсэн эмэгтэйчүүдээс эмчийн хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоог хувиар илэрхийлнэ. Энэ үзүүлэлтийг эмчийн хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмсний хугацаа, хяналтанд хамрагдсан тоог үл харгалзан тооцож гаргана. Жирэмсний хяналтын хувийг эрт (эхний 3 сартайд) буюу хожуу (7 ба түүнээс дээш сартайд) үеийн хяналтын хувь гэж хугацаагаар ялгаж тооцно³.
- 18. Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент:** Тухайн жилийн өсвөр насны 1000 охидод ногдох өсвөр насны охидын төрөлтийн тоог илэрхийлнэ. Өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлтийг тодорхойлохдоо нөхөн үржихүйн насны буюу 15-19 насны охидыг хамруулна⁶.
- 19. Өсвөр насны охидын төрөлтийн хувь:** Тухайн жилийн нийт төрөлтийн дунд өсвөр насны охидын төрөлтийн эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ⁶.
- 20. Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь:** Жирэмсний үед эмнэлгийн хяналтанд хамрагдаж, зөвлөгөө авах, эх барих, шинээр төрсөн хүүхдийг асрах талаар тусгайлан сургасан эмнэлгийн ажилтаны эх барьсан төрөлтийн тоог илэрхийлнэ⁴.
- 21. Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн арга хэрэглээний хувь:** Тухайн жилийн эцсийн байдлаар (судалгааны үед) нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдэд жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн аль нэгийг хэрэглэдэг эмэгтэйчүүдийн эзлэх тоо хэмжээг илэрхийлнэ. Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгсэл гэдэгт бэлгэвч (эрэгтэй, эмэгтэй) ерөндөг, суулгац (дааврын), жирэмслэхээс сэргийлэх эм, тариа, үтрээний хаалт, умайн хүзүүний таглаа, үрийн суваг, умайн гуурс боох мэс ажилбар зэрэг хамаарна³.
- 22. Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь:** Тухайн жилд жирэмсний хяналтанд хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдээс жирэмсний хяналтанд 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн тоог хувиар илэрхийлнэ¹.
- 23. Үр хөндөлтийн харьцаа:** Жирэмсний 22 долоо хоног хүртэл хугацаанд эмнэлгийн цэвэр, ая тухтай орчинд жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслах мэс ажилбарыг үр хөндөлт гэнэ. Жирэмсний эхний 12 долоо хоног дотор үр хөврөлийг авах ажилбарыг эрт үеийн, 13-22 долоо хоног хүртэл хугацаанд ураг авах ажилбарыг хожуу үеийн үр хөндөлт гэнэ. Үр хөндөлтийн харьцаа нь 1000 амьд төрөлтөд ногдох үр хөндөлтийн тоогоор илэрхийлэгдэнэ³.
- 24. Үр хөндөлтийн тусгай коэффициент:** Нөхөн үржихүйн насны (15-49 насны) 1 000 эмэгтэйд ногдох үр хөндөлтийн тоог илэрхийлнэ.
- 25. Өвчлөлийн түвшин:** Тухайн жилийн 10 000 эсвэл 100 000 хүн амд ногдох шинээр бүртгэгдсэн тухайн өвчний тохиолдлын тоог илэрхийлнэ. Өвчлөлийн давтамж, гарах шалтгаан, тархалтыг судалснаар тухайн төрлийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга замыг тодорхойлно³.
- 26. Амбулаторийн өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар:** Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан нь амбулаторид бүртгэгдсэн өвчлөлийн түвшингээр тэргүүлж буй эхний 10 эмгэг (Өвчний олон улсын 10 дугаар ангилал (ӨОУА-10)-ын дагуу) буюу өвчлөлөөр илэрхийлэгдэнэ. Өвчний олон улсын 10 дугаар ангилал гэж Анагаах ухааны практикт тохиолддог бүх өвчлөлийг тодорхой шалгуурын дагуу ангилан бүлэглэсэн тогтолцоог хэлнэ. Монгол Улсад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан Өвчний олон улсын 10 дугаар ангиллыг

хэрэглэж байна. Уг ангилалд амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин, шээс бэлгэсний тогтолцооны өвчин, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант өвчний үр дагавар, жирэмслэх, төрөх, төрсний дараахь үе, мэдрэлийн тогтолцооны өвчин, халдварт ба шимэгчит зарим өвчин, яс булчингийн тогтолцоо, холбох нэхдэсийн өвчин, хавдар, цус, цус бүтээх эрхтний өвчин ба дархлааны механизм хамарсан зарим эмгэг, дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин, сэтгэцийн ба аягийн эмгэг, нүд ба түүний дайврын өвчин, чих ба хөхөнцрийн өвчин, арьс халимны өвчин, төрөх тойрны (перинатал) үед үүсэх зарим оёг, төрөлхийн гажиг, хэв гажил өнгөт цогцын гажуудал, хаа ч ангилаагүй хам шинж тэмдэг багтана³. (Шинэчлсэн орчуулгын хувилбар; Эрүүл мэндийн сайдын 2009 оны 1 дүгээр сарын 20-ны 28 тоот тушаалаар).

- 27. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн (стационарийн) өвчлөл тэргүүлэх 10 шалтгаанаар:** Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан нь хэвтэн эмчлүүлсэн (бүртгэгдсэн) өвчлөлийн түвшингээр тэргүүлж буй эхний 10 эмгэг (Өвчний олон улсын 10 дугаар ангилал (ӨОУА-10)-ын дагуу) өвчлөлөөр илэрхийлэгдэнэ³.
- 28. Өвчний тархалтын түвшин:** Тухайн жилийн 100 000 хүнд ногдох тухайн өвчнөөр өвчилсөн тохиолдлын тархалтын тоог илэрхийлнэ. Энэ үзүүлэлтийг тооцоходоо тухайн өвчнөөр өвчилсөн нийт тохиолдлыг (урьд өмнө нь өвчилсөн нийт тохиолдол) хамруулна³.
- 29. Өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшин:** Хүн амын жилийн дундаж тоонд ногдох тухайн өвчнөөр өвчилж нас барсан хүний тоог илэрхийлнэ.
- 30. Хүн амын нас баралт, тэргүүлэх 10 шалтгаанаар:** Хүн амын нас баралтын тэргүүлэх 10 шалтгаан нь тайлангийн жилд бүртгэгдсэн нас баралтын түвшингээр тэргүүлж буй эхний 10 өвчнөөр нас барсан хүний тоог илэрхийлнэ.
- 31. Эмнэлэгт нас баралтын хувь:** Тухайн жилд нийт нас барсан тохиолдлоос эмнэлэгт нас барсан хүний тоог хувиар илэрхийлнэ³.
- 32. Эмнэлгийн нас баралтын хувь:** Тухайн жилд эмнэлэгт нас барсан нийт тохиолдлоос эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан тохиолдлын тоог хувиар илэрхийлнэ³.
- 33. Хоног болоогүй нас баралтын хувь:** Тухайн жилд эмнэлэгт нас барсан нийт тохиолдлоос эмнэлэгт нэг хоног болоогүй нас барсан тохиолдлын тоог хувиар илэрхийлнэ. Тухайн өвчтөнийг эмнэлэгт хүлээн авч, өвчний түүх нээсэн цагаас хойш 24 цагийн дотор нас барсан тохиолдлыг хамруулна³.
- 34. Нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь:** Нэг хүртэлх насны (0-364 хоногтой) нийт хүүхдээс эрүүл мэндийн идэвхтэй хяналтанд хамрагдсан хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ. Эрүүл мэндийн идэвхтэй үзлэгийг 1 хүртэлх насны хүүхдэд 28 хоног хүртэл нь долоо хоног тутамд 1 удаа, 28 хоногоос нэг нас хүртэл нь сар тутамд нэг удаа (нийт 15 удаа) гэрээр хийнэ³.
- 35. 1-5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь:** 1-5 хүртэлх (365-хоногоос 4 нас 364 хоногтой) насны нийт хүүхдээс идэвхтэй хяналтанд хамрагдсан хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ. Эрүүл мэндийн үзлэгийг 3 хүртэлх насны хүүхдэд сар тутам нэг удаа, 3-5 хүртэлх насны хүүхдэд улирал тутамд 1 удаа гэрээр идэвхтэй үзлэг хийхийг хэлнэ³ (нийт 44 удаа).
- 36. Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь:** Судалгаанд хамрагдсан нийт өрхийн дунд иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн тоог хувиар илэрхийлнэ³.
- 37. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт:** 5-6 насны хүн амын дунд байгаа шүд цоорох өвчтэй (нэг буюу түүнээс дээш цоорсон, нэг буюу түүнээс дээш

- ломбодсон, нэг буюу түүнээс дээш цоорлын улмаас авагдсан шүдтэй) хүүхдийн тоог хувиар илэрхийлнэ⁴.
- 38. 10 000 хүн амд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо:** Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 10 000 хүн амд ногдохоор илэрхийлнэ³.
- 39. 10 000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо:** Тухайн жилд ажилласан эмнэлгийн нийт орны тоог 10 000 хүн амд ногдохоор илэрхийлнэ³.
- 40. Орны эргэлт:** Эмнэлгийн нэг орыг тухайн жилд хэдэн өвчтөн хэвтэж ашигласныг илэрхийлнэ. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нийт өвчтөний тоог тухайн жилд ашиглагдсан орны дундаж тоонд харьцуулсан үзүүлэлтээр илэрхийлнэ³.
- 41. 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо:** Тухайн жилд 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоог илэрхийлнэ. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн мэргэжлийн болон эмнэлгийн бус мэргэжлийн бүх ажиллагчдыг хамруулна. Мөн 10 000 хүн амд ногдох их эмч, дунд мэргэжилтэн, сувилагчдын тоог энэ аргачлалаар тооцно³.
- 42. Нэг их эмч (сувилагч)-д ногдох хүн амын тоо:** Эрүүл мэндийн салбарын нэг их эмчид, (сувилагчид) ногдох хүн амын тоог илэрхийлнэ³.
- 43. Жирэмсэн эмэгтэйчүүдийн ХДХВ/ДОХ-ын тархалт/хувь:** Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд байгаа ХДХВ/ДОХ-ын халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоог хувиар илэрхийлнэ⁴.
- 44. 15-24 насны залуучуудын ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт /хувь:** 15-24 насны нийт залуучуудын дунд ХДХВ/ДОХ-ын халдвартай энэ насны залуучууд хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ⁴.
- 45. ХДХВ/ДОХ-ын улмаас нас барсан хүний тоо /100 000 хүн тутамд/:** 100 000 хүн амд ногдох ХДХВ/ДОХ-ын улмаас тухайн жилд нас барсан тохиолдлын тоог илэрхийлнэ².
- 46. Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт /100 000 хүн тутамд/:** Тухайн жилд 100 000 хүн амд ногдох сүрьеэ өвчний улмаас нас барсан хүний тоог илэрхийлнэ⁴.
- 47. Сүрьеэ өвчний өвчлөлийн түвшин /100 000 хүн тутамд/:** Тухайн жилд 100 000 хүн амд ногдох шинээр бүртгэгдсэн сүрьеэ өвчний тохиолдлын тоог илэрхийлнэ⁴.
- 48. Сүрьеэ өвчний тархалтын түвшин /100 000 хүн тутамд/:** Тухайн жилд 100 000 хүнд ногдох сүрьеэ өвчнөөр өвчлөгчдийн тоог илэрхийлнэ⁴.
- 49. Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь:** Шууд Хяналттай Богино Хугацааны Эмчилгээнд (ШХБХЭ/DOTS) хамрагдсан сүрьеэтэй өвчитнүүдээс бүрэн эдгэрсэн тохиолдлын тоог хувиар илэрхийлнэ. “Сүрьеэгийн бүрэн эдгэрэлт”- эмчилгээ эхлэхээс өмнө түрхэц эерэг байсан сүрьеэтэй өвчтөн богино хугацааны шууд эмчилгээг бүрэн хийлгэж, 5 дахь сарын эцэст болон эмчилгээний төгсгөлд 2 ба түүнээс дээш удаа дараалан түрхэц сөрөг болсон тохиолдлыг хэлнэ⁴.
- 50. Нэг хүний жилд эмнэлгээр үйлчлүүлсэн дундаж тоо:** Өвчтөний тухайн жилд амбулаториор үйлчлүүлсэн тоог илэрхийлнэ³.
- 51. Эрүүл мэндийн нийт зардал:** Улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас болон хувь хүний эрүүл мэндэд зарцуулсан өөрөө төлөх зардлын хэмжээ болно³.
- 52. Улсын төсөвт эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь:** Тухайн жилд улсын нийт төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулсан зардлын эзлэх хэмжээг хувиар илэрхийлнэ³.

- 53. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь:** Тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний дүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хэмжээг хувиар илэрхийлнэ³.
- 54. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал:** Тухайн жилд эрүүл мэндийн салбарт зарцуулсан нийт зардлыг хүн амын жилийн дундаж тоонд харьцуулсан үзүүлэлт³.
- 55. Хөгжлийн бэрхшээлтэй хүн:** Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" хүн гэнэ¹².
- 56. Хөгжлийн бэрхшээлийн төрөл:** Хөгжлийн бэрхшээлийн үүсэл, гарлаас хамаарч төрөлхийн, олдмол гэсэн 2 төрөлд ангилна¹².
- i. **Төрөлхийн хөгжлийн бэрхшээл:** Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ¹².
 - ii. **Олдмол хөгжлийн бэрхшээл:** Ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан тохиолдлыг хэлнэ¹².
- 57. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр:** Хөгжлийн бэрхшээлийг дараахь үндсэн 6 хэлбэрээр бүлэглэнэ¹². Үүнд:
- i. **Харааны:** Харааны эрхтний гэмтэл, согогийн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон байдал¹²
 - ii. **Ярианы:** Хэл, ярианы эрхтний гэмтэл, согогийн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон байдал¹²
 - iii. **Сонсголын:** Сонсголын эрхтний гэмтэл, согогийн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон байдал¹²
 - iv. **Хөдөлгөөний:** Биеийнхээ тодорхой хэсгийг хөдөлгөх эсвэл ашиглах чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон байдал¹²
 - v. **Сэтгэцийн:** Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх, ойлгох, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илэрхийлэгддэг бөгөөд үүнийхээ улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэж чадахгүй болсон байдал¹²
 - vi. **Бусад:** Хөгжлийн бэрхшээлүүдийн дээр дурьдсан хэлбэрүүдээс бусад хэлбэрийг үүнд хамруулна. Тухайлбал, дотор эрхтний, уналт, таталт, эсвэл 1-ээс дээш хэлбэрийн хөгжлийн бэрхшээл нэг хүнд хамт илэрч байвал хавсарсан гэж үзэх бөгөөд үүнийг бусад гэсэн хэлбэрт оруулна¹².

III. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Эхийн эрүүл мэнд

1.1 Жирэмсний хяналтын хувь

Тооцох арга зүй: Эмнэлгийн хяналтанд (тухайн жилд) хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоог нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЖХХ = \frac{ЖЭ_{хх}}{ЖЭ} * 100$$

ЖХХ – Жирэмсний хяналтын хувь

ЖЭ_{хх} – Хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо

ЖЭ – Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.2 Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд жирэмсний хяналтанд 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн тоог тухайн жилд төрсөн нийт эхийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЖЭХ_{(ххэ)} = \frac{ЖЭТ_{(хх)}}{ТЭ} * 100$$

ЖЭХ (ххэ) – Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

ЖЭТ_(хх) – Жирэмсний хяналтанд 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо

ТЭ – Нийт төрсөн эхийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.3 Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн тоог тухайн жилийн нийт төрөлтийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЭТХ_{(эма)} = \frac{ЭТТ_{(эма)}}{НТ} * 100$$

$ЭТХ_{(эма)}$ – Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь
 $ЭТТ_{(эма)}$ – Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн тоо
 $НТ$ – Нийт төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа

1.4 Эхийн эндэгдлийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд эндсэн эхийн тоог 15-49 насны (төрөх насны) эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$ЭЭТ = \frac{ЭЭ}{ТНЭ_{(15-49 \text{ насны})}} * 100\ 000$$

$ЭЭТ$ – Эхийн эндэгдлийн түвшин
 $ЭЭ$ – Нийт эндсэн эхийн тоо
 $ТНЭ_{(15-49 \text{ насны})}$ – Нөхөн үржихүйн насны (15-49 насны) эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.5 Эхийн эндэгдлийн харьцаа

Тооцох арга зүй: Тухайн жилд эндсэн эхийн тоог нийт амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$ЭЭХ = \frac{ЭЭ}{АТ} * 100\ 000$$

$ЭЭХ$ – Эхийн эндэгдлийн харьцаа
 $ЭЭ$ – Нийт эндсэн эхийн тоо
 $АТ$ – Нийт амьд төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн

тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.
Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, сарын бюллетень

1.6 Үр хөндөлтийн харьцаа

Тооцох арга зүй: Тухайн жилд үр хөндүүлсэн нийт тохиолдлын тоог нийт амьд төрөлтийн тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$YXX = \frac{YX}{AT} * 1000$$

YXX-Үр хөндөлтийн харьцаа

YX- Үр хөндөлтийн тоо

AT-Нийт амьд төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.7 Үр хөндөлтийн тусгай коэффициент

Тооцох арга зүй: Тухайн жилд үр хөндүүлсэн нийт тохиолдлын тоог нөхөн үржихүйн насны (15-49 насны) нийт эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж,1000-аар үржүүлнэ.

$$YXTK_{(тусгай)} = \frac{YX}{HЭ_{(15-49 \text{ насны})}} * 1000$$

YXTK_(тусгай)- Үр хөндөлтийн тусгай коэффициент

YX- Үр хөндөлтийн тоо

HЭ_{15-49 насны} – Нөхөн үржихүйн насны (15-49 насны) нийт эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, нөхөн үржихүйн насны бүлгээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.8 Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн арга хэрэглээний хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн аргын аль нэгийг хэрэглэдэг нөхөн үржихүйн насны (15-49 насны) нийт эмэгтэйчүүдийн тоог нөхөн үржихүйн насны (15-49 насны) тухайн жилийн нийт эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ЖАХ} = \frac{\text{ЖАХ}_{(15-49 \text{ насны})}}{\text{НЭ}_{(15-49 \text{ насны})}} * 100$$

ЖАХ – Жирэмслэхээс хамгаалах орчин үеийн арга хэрэглээний хувь
ЖАХ_(15-49 насны) – Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн аргын аль нэгийг хэрэглэдэг нөхөн үржихүйн насны (15-49 насны) нийт эмэгтэйчүүдийн тоо
НЭ_(15-49 насны) – Нөхөн үржихүйн насны (15-49 насны) нийт эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

- **Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд**

1.9 Нярайн эндэгдлийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд төрсний дараахь 28 хоног дотор эндсэн хүүхдийн тоог тухайн жилд нийт амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$\text{ЭТ}_{(\text{нярайн})} = \frac{\text{ЭХТ}_{(28 \text{ хоног})}}{\text{АТ}} * 1000$$

ЭТ_(нярайн) – Нялхсын эндэгдлийн түвшин
ЭХТ_(28 хоног) – Төрсний дараахь 28 хоногийн дотор эндсэн хүүхдийн тоо
АТ – Нийт амьд төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа.

1.10 Нялхсын эндэгдлийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$\text{ЭТ}_{(\text{нялхсын})} = \frac{\text{ЭХТ}_{(1 \text{ хүртэлх})}}{\text{АТ}} * 1000$$

ЭТ_(нялхсын) – Нялхсын эндэгдлийн түвшин
ЭХТ_(1 хүртэлх) – Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо
АТ – Нийт амьд төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн

тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.
Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, сарын бюллетень

1.11. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн нийт хүүхдийн тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$ЭТ_{(5 \text{ хүртэлх})} = \frac{ЭХТ_{(5 \text{ хүртэлх})}}{АТ} * 1000$$

ЭТ_(5 хүртэлх) – Нялхсын эндэгдлийн түвшин
ЭХТ_(5 хүртэлх) – Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
АТ – Нийт амьд төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.
Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, сарын бюллетень

1.12 Зөвхөн хөхөөр хооллодог 0-6 сартай хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд зөвхөн хөхөөр хооллосон 0-6 сартай хүүхдийн тоог тухайн жилийн 0-6 сартай нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЗХХ_{(0-6 \text{ сар})} = \frac{ХХТ_{(0-6 \text{ сар})}}{ХТ_{(0-6 \text{ сар})}} * 100$$

ЗХХ_(0-6 сар) - Зөвхөн хөхөөр хооллодог хүүхдийн эзлэх хувь
ХХТ_(0-6 сар) - Хөхөөр хооллодог 0-6 сартай хүүхдийн тоо
ХТ_(0-6 сар) - 0-6 сартай хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа, ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаагаар 5 жил тутам тооцно.
Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаа

1.13 Нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн тоог 1 хүртэлх насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ХХХ_{(1 \text{ нас хүртэлх})} = \frac{ХХТ_{(1 \text{ хүртэлх})}}{ХТ_{(1 \text{ хүртэлх})}} * 100$$

$XXX_{(1 \text{ нас хүртэлх})}$ - Нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь
 $ХХТ_{(1 \text{ хүртэлх})}$ - Хөхөөр хооллодог нэг хүртэлх насны хүүхдийн тоо
 $ХТ_{(1 \text{ хүртэлх})}$ - Нэг хүртэлх насны хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа (ЗГХА-ЭМГ), 5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаа

1.14 Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувь

Тооцох арга зүй: Нэг хүртэлх насны хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн тоог нэг хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн нийт тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ХХЭ_{(хувь)} = \frac{ХА_{(хх)}^{ЭМ}}{ХА_{(хх)}^{ЭМ}} * 100$$

$ХХЭ_{(хувь)}$ - Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувь

$ХА_{(хх)}^{ЭМ}$ - Нэг хүртэлх насны хүүхдээ хөхөөрөө хооллож байгаа эмэгтэйчүүдийн тоо

$ХА_{(х)}^{ЭМ}$ - Нэг хүртэлх насны хүүхэдтэй нийт эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

1.15 Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: 5 хүртэлх насны тураалтай хүүхдийн тоог 5 хүртэлх насны хүүхдийн нийт тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ТЭХ_{(5 \text{ хүртэлх})} = \frac{ТХТ_{(5 \text{ хүртэлх})}}{ХТ_{(5 \text{ хүртэлх})}} * 100$$

$ТЭХ_{(5 \text{ хүртэлх})}$ - 5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь

$ТХТ_{(5 \text{ хүртэлх})}$ - Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн тоо

$ХТ_{(5 \text{ хүртэлх})}$ - Тав хүртэлх насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа (ЗГХА-ЭМГ), 5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаа

1.16 Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн тоог 5 хүртэлх насны хүүхдийн нийт тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

$$ӨХХ_{(5 \text{ хүртэлх})} = \frac{ӨХТ_{(5 \text{ хүртэлх})}}{ХТ_{(5 \text{ хүртэлх})}} * 100$$

$ӨХХ_{(5 \text{ хүртэлх})}$ - Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь

$ӨХТ_{(5 \text{ хүртэлх})}$ - Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн тоо

$ХТ_{(5 \text{ хүртэлх})}$ - Тав хүртэлх насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа (ЗГХА-ЭМГ), 5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаа

1.17 Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь

Тооцох арга зүй: 5 хүртэлх насны туранхай хүүхдийн тоог 5 хүртэлх насны хүүхдийн нийт тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ТурХХ}_{(5 \text{ хүртэлх})} = \frac{\text{ТХТ}_{5 \text{ хүртэлх}}}{\text{ХТ}_{5 \text{ хүртэлх}}} * 100$$

*ТурХХ*_(5 хүртэлх) - Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь

*ТХТ*_(5 хүртэлх) - Тав хүртэлх насны туранхай хүүхдийн тоо

*ХТ*_(5 хүртэлх) - Тав хүртэлх насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа (ЗГХА-ЭМГ), 5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Хүүхэд хөгжил судалгаа

1.18 Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент

Тооцох арга зүй: Тухайн жилийн өсвөр насны жирэмсэн охидын тоог өсвөр насны нийт охидын тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$\text{ОЖК}_{(ө.н)} = \frac{\text{ЖОТ}_{(ө.н)}}{\text{ОТ}_{(ө.н)}} * 1000$$

*ОЖК*_(ө.н) - Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент

*ЖОТ*_(ө.н) - Өсвөр насны жирэмсэн охидын тоо

*ОТ*_(ө.н) - Өсвөр насны нийт охидын тоо

Мэдээллийн эх үүсвэр: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.19 Өсвөр насны охидын жирэмслэлтийн хувь

Тооцох арга зүй: Тухайн жилийн өсвөр насны жирэмсэн охидын тоог жирэмсэн нийт эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ОЖХ}_{(ө.н)} = \frac{\text{ЖОТ}_{(ө.н)}}{\text{ЖЭ}} * 100$$

*ОЖХ*_(ө.н) - Өсвөр насны охидын жирэмслэлтийн хувь

ЖОТ_(ө.н) - Өсвөр насны жирэмсэн охидын тоо
ЖЭ - Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), 5 жил тутам; Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.20 Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент

Тооцох арга зүй: Тухайн жилийн өсвөр насны охидын төрөлтийн тоог өсвөр насны нийт охидын тоонд харьцуулж, 1 000-аар үржүүлнэ.

$$ОТК_{(ө.н)} = \frac{ОТТ_{(ө.н)}}{ОТ_{(ө.н)}} * 1000$$

ОТК_(ө.н) - Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент

ОТТ_(ө.н) - Өсвөр насны охидын төрөлтийн тоо

ОТ_(ө.н) - Өсвөр насны нийт охидийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа

1.21 Өсвөр насны охидын төрөлтийн хувь

Тооцох арга зүй: Тухайн жилийн өсвөр насны охидын төрөлтийн тоог нийт төрөлтийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ОТХ_{(ө.н)} = \frac{ОТТ_{(ө.н)}}{НТ} * 100$$

ОТХ_(ө.н) - Өсвөр насны охидын төрөлтийн хувь

ОТТ_(ө.н) - Өсвөр насны охидын төрөлтийн тоо

НТ - Нийт төрөлтийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны ХАНҮЭМ-ийн судалгаа

2. ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ

2.1 Өвчлөлийн түвшин

Тооцох арга зүй: Тухайн жилд шинээр бүртгэгдсэн өвчний тохиолдлын тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж 10 000-аар үржүүлнэ.

$$\Theta T = \frac{\text{ШБӨ}}{\text{ХА}_{(\text{дун})}} * 10\ 000$$

ΘT - Өвчлөлийн түвшин

ШБӨ - Тухайн жилд шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо

$\text{ХА}_{(\text{дун})}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Хүн амын амбулаторийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, өвчний ангиллаар тооцох боломжтой.

2.2 Амбулаторийн өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн амбулаторийн тэргүүлэх өвчний тохиолдлын тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$A\Theta\text{Ш}_{(\text{т.10})} = \frac{\Theta\text{ТТ}_{(\text{б.а.т})}}{\text{ХА}_{(\text{дун})}} * 10\ 000$$

$A\Theta\text{Ш}_{(\text{т.10})}$ - Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан

$\Theta\text{ТТ}_{(\text{б.а.т})}$ - Тухайн жилд бүртгэгдсэн амбулаторийн тэргүүлэх өвчний тохиолдлын тоо

$\text{ХА}_{(\text{дун})}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Хүн амын амбулаторийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

2.3 Эмнэлэгт (стационарт) хэвтэн эмчлүүлж буй өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй тэргүүлэх өвчний тохиолдлын тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$C\Theta\text{Ш}_{(\text{т.10})} = \frac{C\text{ТТ}_{(\text{б.с.т})}}{\text{ХА}_{(\text{дун})}} * 10\ 000$$

$C\Theta\text{Ш}_{(\text{т.10})}$ - Стационарийн өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар

$C\text{ТТ}_{(\text{б.с.т})}$ - Тухайн жилд бүртгэгдсэн стационарийн тэргүүлэх өвчний тохиолдлын тоо

$\text{ХА}_{(\text{дун})}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Хүн амын стационарийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

2.4 Өвчний тархалтын түвшин

Тооцох арга зүй: Тухайн өвчнөөр өвчилсөн нийт хүний тоог, тухайн жилийн оны эцсийн хүн амын нийт тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$\Theta\text{TТ} = \frac{\Theta\text{ХТ}_{(т,ө)}}{\text{ХА}_{эц}} * 100\ 000$$

$\Theta\text{TТ}$ - Өвчний тархалтын түвшин

$\Theta\text{ХТ}_{(т,ө)}$ - Тухайн өвчнөөр өвчилсөн нийт хүний тоо

$\text{ХА}_{эц}$ - Хүн амын жилийн эцсийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ, Хүн амын амбулаторийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

2.5 Өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшин

Тооцох арга зүй: Тухайн өвчнөөр өвчилж нас барсан хүний тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$\text{НБТ}_{(ө,а)} = \frac{\text{НБХ}_{(т,ө)}}{\text{ХА}_{(дун)}} * 10\ 000$$

$\text{НБТ}_{(ө,а)}$ - Өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшин

$\text{НБХ}_{(т,ө)}$ - Тухайн өвчнөөр өвчилж нас барсан хүний тоо

$\text{ХА}_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

2.6 Хүн амын нас баралтын түвшин, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тооцох арга зүй: Тухайн жилд бүртгэгдсэн нас баралтын тэргүүлэх 10 шалтгаанаарх тохиолдлын нийт тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$\text{НБТШ}_{(т,10)} = \frac{\text{НТТ}_{(т,10)}}{\text{ХА}_{(дун)}} * 10\ 000$$

$\text{НБТШ}_{(ө,а)}$ - Хүн амын нас баралт, тэргүүлэх 10 шалтгаанаар

$\text{НТТ}_{(т,10)}$ - Тухайн жилд бүртгэгдсэн нас баралтын тэргүүлэх тохиолдлын тоо

$\text{ХА}_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Хүн амын нас баралтын тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

2.7 Эмнэлэгт нас баралтын хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд эмнэлэгт нас барсан хүний тоог тухайн жилийн нас барсан нийт тохиолдлын тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ЭНБ}_x = \frac{\text{НБХТ}_3}{\text{НБТ}} * 100$$

*ЭНБ_x – Эмнэлэгт нас баралтын хувь
НБХТ₃ – Эмнэлэгт нас барсан хүний тоо
НБТ – Нийт нас баралтын тоо*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас жил, жилийн тайлан (ҮСХ), Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), сар, жилээр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

2.8 Эмнэлгийн нас баралтын хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд эмнэлэгт нас барсан хүний тоог тухайн жилд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн нийт тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{НБХ}_3 = \frac{\text{НБХТ}_3}{\text{ХЭТ}} * 100$$

*НБХ₃ – Эмнэлгийн нас баралтын хувь
НБХТ₃ – Эмнэлэгт нас барсан хүний тоо
ХЭТ – Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо*

Мэдээллийн эх үүсвэр: Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ, Хүн амын насбаралтын тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

2.9 Хоног болоогүй нас баралтын хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд эмнэлэгт хоног болоогүй нас барсан тохиолдлын тоог тухайн жилийн эмнэлэгт нас барсан нийт тохиолдлын тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{НБХ}_{\text{ХБ}} = \frac{\text{НБТ}}{\text{НБТ}_3} * 100$$

*НБХ_{ХБ} – Хоног болоогүй нас баралтын хувь
НБТ_{ХБ} – Хоног болоогүй нас барсан тохиолдлын тоо
НБТ₃ – Эмнэлэгт нас барсан нийт тохиолдлын тоо*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүн амын өвчлөл, эндэгдлийн сарын мэдээ (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3. БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1 Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан хувь

Тооцох арга зүй: Тухайн жилийн заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан нэг хүртэлх насны хүүхдийн тоог нэг хүртэлх насны хүүхдийн нийт тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ДХХ_{зх} = \frac{ДХХ_{1х}}{ХТ_{1х}} * 100$$

ДХХ_{зх} – Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан хувь

ДХХТ_{1х} – Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан нэг хүртэлх насны хүүхдийн тоо

ХТ_{1х} – Нэг хүртэлх насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэл, дархлаажуулалтын төрлөөр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл, Хүүхэд хөгжил судалгаа

3.2 Нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд идэвхтэй хяналтад хамрагдсан нэг хүртэлх насны хүүхдийн тоог нэг хүртэлх насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ИХХ_{1 \text{ хүртэлх}} = \frac{ИХХТ_{1 \text{ хүртэлх}}}{ХТ_{1 \text{ хүртэлх}}} * 100$$

ИХХ_(1 хүртэлх) – Нэг хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь

ИХХТ_(1 хүртэлх) – Идэвхитэй хяналтанд хамрагдсан нэг хүртэлх насны хүүхдийн тоо

ХТ_(1 хүртэлх) – Нэг хүртэлх насны хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.3 1-5 хүртэлх насны идэвхтэй хяналтын хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд идэвхтэй хяналтад хамрагдсан 1-5 хүртэлх насны хүүхдийн тоог тухайн жилийн 1-5 хүртэлх насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ИХХ_{(1-5)} = \frac{ИХХТ_{(1-5)}}{ХТ_{(1-5)}} * 100$$

$IХХ_{(1-5)}$ – 1-5 хүртэлх насны идэвхтэй хяналтын хувь
 $IХХТ_{(1-5)}$ – Идэвхтэй хяналтанд хамрагдсан 1-5 хүртэлх насны хүүхдийн тоо
 $ХТ_{(1-5)}$ - 1-5 хүртэлх насны хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа, 5 жил тутам; Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.4 Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь

Тооцох арга зүй: Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн тоог нийт өрхийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\Theta ЭХ_{(ИДХ)} = \frac{\Theta Т_{(ИДХ)}}{\Theta Т} * 100$$

$\Theta ЭХ_{(ИДХ)}$ - Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь
 $\Theta Т_{(ИДХ)}$ - Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн тоо
 $\Theta Т$ - Нийт өрхийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Хүүхэд хөгжил судалгаа (ҮСХ), Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн байдлын судалгаа (ЗГХА-ЭМГ), 5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.5 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт

Тооцох арга зүй: 5-6 настай шүд цоорох өвчтэй хүүхдийн тоог 5-6 насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\Theta Т_{шц(5-6)} = \frac{\Theta ХТ_{шц(5-6)}}{ХТ_{шц(5-6)}}$$

$\Theta Т_{шц(5-6)}$ - 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт
 $\Theta ХТ_{шц(5-6)}$ - Шүд цоорох өвчтэй 5-6 настай хүүхдийн тоо
 $ХТХТ_{шц(5-6)}$ - 5-6 насны нийт хүүхдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шүдний өвчлөлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн түүвэр судалгаа (ЭМЯ), 3-5 жил тутам тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ЭМЯ-ны Шүдний өвчлөлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

3.6 10 000 хүн амд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо

Тооцох арга зүй: Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$ХЭТ_{(10\ 000)} = \frac{ХЭТ}{ХА_{(дун)}} * 10\ 000$$

$ХЭТ_{(10\ 000)}$ – 10 000 хүн амд ногдох эмнэлэгт нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо
 $ХЭТ$ - Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо
 $ХА_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний жилийн тайлан, Хүн амын стационарийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.7 10 000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо

Тооцох арга зүй: Тухайн жилд үйл ажиллагаа явуулсан эмнэлгийн нийт орны тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$\text{ЭОТ}_{(10\,000)} = \frac{\text{НОТ}_{(\text{ЭА})}}{\text{ХА}_{(\text{ДУН})}} * 10\,000$$

ЭОТ_(10 000) – 10 000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо

НОТ_(ЭА) – Эмнэлгийн ашигласан нийт орны тоо

ХА_(ДУН) – Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний жилийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.8 Орны эргэлт

Тооцох арга зүй: Хэвтэн эмчлүүлсэн нийт өвчтөний тоог тухайн жилд ашиглагдсан эмнэлгийн дундаж орны тоонд харьцуулна.

$$\text{ЭОЭ} = \frac{\text{ЭӨТ}}{\text{ЖДО}}$$

ЭОЭ – Эмнэлгийн орны эргэлт

ЭӨТ – Эмчлүүлсэн өвчтөний тоо

ЖДО – Эмнэлгийн жилийн дундаж орны тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан, (ҮСХ), Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний жилийн тайлан (ЭМЯ) жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

3.9 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо

Тооцох арга зүй: Эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$\text{АТ}_{(10\,000\ \text{ЭМС})} = \frac{\text{АТ}_{(\text{ЭМС})}}{\text{ХА}_{(\text{ДУН})}} * 10\,000$$

АТ_(10 000 ЭМС) – 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо

АТ_(ЭМС) – Эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо

ХА_(ДУН) – Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний жилийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

3.10 Нэг их эмчид, сувилагчид ногдох хүн амын тоо

Тооцох арга зүй: Хүн амын жилийн дундаж тоог нийт их эмч (сувилагч)-ийн тоонд харьцуулж, 10 000-аар үржүүлнэ.

$$\text{ИСТ} = \frac{\text{ИСТ}_{(\text{нийт})}}{\text{ХА}_{(\text{дун})}} * 10\ 000$$

ИСТ - Нэг их эмч (сувилагч)-д ногдох хүн амын тоо

ИСТ_(нийт) – Нийт их эмч (сувилагч)-ийн тоо

ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Эрүүл мэндийн байгууллагын хүн хүчний жилийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

3.11 Жирэмсэн эмэгтэйчүүдийн ХДХВ/ДОХ-ын тархалт /хувь/

Тооцох арга зүй: ХДХВ/ДОХ-ын халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоог нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ТХ}_{\text{ХДХВ/ДОХ}}^{\text{жэ}} = \frac{\text{ЖЭТ}_{(\text{хдхв/дох})}}{\text{ЖЭ}} * 100$$

ТХ_{ХДХВ/ДОХ}^{жэ} - Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт хувь/

ЖЭТ_(хдхв/дох) - ХДХВ/ДОХ-ын халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо

ЖЭ - Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Халдварт өвчнийг мэдээлэх хуудас, БЗДХ-ыг мэдээлэх хуудас (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.12 15-24 насны залуучуудын ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт (хувь)

Тооцох арга зүй: ХДХВ/ДОХ-ын халдвар авсан 15-24 насны залуучуудын тоог 15-24 насны хүн амын тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$\text{ТХ}_{\text{ХДХВ/ДОХ}}^{15-24} = \frac{\text{ХА}_{\text{ХДХВ/ДОХ}}^{15-24}}{\text{ХА}_{(15-24)}} * 100$$

ТХ_{ХДХВ/ДОХ}¹⁵⁻²⁴ - 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт /хувь/

ХА_{ХДХВ/ДОХ}¹⁵⁻²⁴ - ХДХВ/ДОХ-ын халдвар авсан 15-24 насны хүн амын тоо

ХА₍₁₅₋₂₄₎ - 15-24 насны хүн амын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Халдварт өвчнийг мэдээлэх хуудас, БЗДХ-ыг мэдээлэх хуудас (ЭМЯ), Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр, мөн хүйсээр тооцох боломжтой.

3.13 ХДХВ/ДОХ-ын нас баралтын түвшин /100 000 хүн тутамд/

Тооцох арга зүй: ХДХВ/ДОХ-ын улмаас нас барсан хүний тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$НБТ_{ХДХВ/ДОХ} = \frac{НБХТ_{(ХДХВ/ДОХ)}}{ХА_{(дун)}} * 100\ 000$$

*НБТ_(хдхв/дох) - ХДХВ/ДОХ-ын нас баралтын түвшин
НБХТ_(хдхв/дох) - ХДХВ/ДОХ-оор нас барсан хүний тоо
ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Халдварт өвчнийг мэдээлэх хуудас, БЗДХ-ыг мэдээлэх хуудас (ЭМЯ), Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр, мөн хүйсээр тооцох боломжтой.

3.14 Сүрьеэгээс шалтгаалсан нас баралтын түвшин /100 000 хүн тутамд/

Тооцох арга зүй: Сүрьеэ өвчнөөр нас барсан хүний тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$НБТ_{(с.100\ 000)} = \frac{НБ_{(с)}}{ХА_{(дун)}} * 100\ 000$$

*НБТ_(с.100 000) - Сүрьеэгээс шалтгаалсан нас баралтын түвшин /100 000 хүн тутамд/
НБ_(с) - Сүрьеэ өвчнөөс шалтгаалж нас барсан хүний тоо
ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас(ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.15 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100 000 хүн тутамд/

Тооцох арга зүй: Тухайн жилд шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$\Theta T_{(с.100\ 000)} = \frac{СТ_{(с)}}{ХА_{(дун)}} * 100\ 000$$

*ӨТ_(с.100 000) - Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100 000 хүн тутамд/
СТ_(с) - Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоо
ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо*

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.16 Сүрьеэ өвчний тархалтын түвшин /100 000 хүн тутамд/

Тооцох арга зүй: Тухайн жилд сүрьеэгээр өвчилсөн нийт хүн амын тоог жилийн эцсийн хүн амын тоонд харьцуулж, 100 000-аар үржүүлнэ.

$$\Theta T T_{(с.100\ 000)} = \frac{\Theta T_{(с)}}{ХА_{(эц)}} * 100\ 000$$

$\Theta T T_{(с.100\ 000)}$ - Сүрьеэ өвчний тархалтын түвшин /100 000 хүн тутамд/

$\Theta T_{(с)}$ - Сүрьеэгээр өвчилсөн нийт өвчтөний тоо

$ХА_{(эц)}$ - Хүн амын жилийн эцсийн тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

3.17 Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж эмчилсэн тохиолдлын хувь

Тооцох арга зүй: Тайлангийн жилд Шууд Хяналттай Богино Хугацааны Эмчилгээний (ШХБХЭ/DOTS) дүнд бүрэн эдгэрсэн өвчтөний тоог тайлангийн өмнөх жилд (12-15 сарын өмнө) ШХБХЭ-нд хамрагдсан түрхэц нь эерэг байгаа сүрьеэгийн тохиолдлын тоонд харьцуулж, 100 - гаар үржүүлнэ.

$$\Theta T X_{сoуc} = \frac{\Theta \Theta T}{T T_c} * 100$$

$\Theta T X_{сoуc}$ – Оношлогоо эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь

$\Theta \Theta T$ – Тайлангийн жилд ШХБХЭ-ний дүнд бүрэн эдгэрсэн өвчтөний тоо

$T T_c$ - Тайлангийн өмнөх жилд (12-15 сарын - өмнө) ШХБХЭ-нд хамрагдсан түрхэц нь эерэг байсан сүрьеэгийн тохиолдлын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой

3.18 Нэг хүний жилд эмнэлгээр үйлчлүүлсэн дундаж тоо

Тооцох арга зүй: Амбулаторийн нийт үзлэгийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулна.

$$\Theta Y Д T = \frac{A Y T}{ХА_{(дун)}}$$

$\Theta Y Д T$ – Нэг иргэний жилд эмнэлэгт үзүүлсэн дундаж тоо

$A Y T$ - Амбулаторийн нийт үзлэгийн тоо

$ХА_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Суурин хүн амын жилийн эцсийн тайлан (ҮСХ), Хүн амын амбулаторийн өвчлөлийн тайлан (ЭМЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой.

4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ

4.1. Эрүүл мэндийн нийт зардал

Тооцох арга зүй: Тухайн жилд улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндэд зарцуулсан нийт зардал дээр хувь хүний өөрөө төлөх зардлыг нэмнэ.

$$НЗ_{(э.м)} = ЗЗ_{(у.т.д.с)} + ХЗ$$

НЗ_(э.м) – Эрүүл мэндийн нийт зардал, сая төг

ЗЗ_(у.т.д.с) - Улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндэд зарцуулсан зардал

ХЗ - Хувь хүний өөрөө төлсөн зардал, сая төг

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Улсын төсвийн жинхэнэ гүйцэтгэл (СЯ), жил бүр тооцно.

4.2 Улсын төсөвт эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс зарцуулсан нийт зардлыг улсын нийт төсөвт харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЭМЗЭХ_{(төсөв)} = \frac{ЭМЗЗ}{УТ} * 100$$

ЭМЗЭХ_(төсөв) Улсын төсөвт эрүүл мэндийн салбарын эзлэх хувь

ЭМЗЗ - Эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс зарцуулсан зардал, сая төг

УТ - Улсын нийт төсөв, сая төг

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Улсын төсвийн жинхэнэ гүйцэтгэл (СЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

4.3 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь

Тооцох арга зүй: Тухайн жилд зарцуулсан эрүүл мэндийн нийт зардлыг тухайн оны дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$ЭМЗЭХ_{(днб)} = \frac{ЭМНЗ}{ДНБ} * 100$$

ЭМЗЭХ_(днб) - Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувь

ЭМНЗ - Эрүүл мэндийн нийт зардал, сая төг

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо (ҮСХ), Улсын төсвийн жинхэнэ гүйцэтгэл (СЯ), жил бүр тооцно.

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой
Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

4.4 Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал

Тооцох арга зүй: Тухайн жилд зарцуулсан эрүүл мэндийн нийт зардлыг хүн амын жилийн дундаж тоонд харьцуулна.

$$ЭМЗ_{(1 \text{ хүнд})} = \frac{ЭМНЗ}{ХА_{(дун)}}$$

ЭМЗ_(1 хүнд) – Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал

ЭМНЗ – Эрүүл мэндэд зарцуулсан нийт зардал

ХА_(дун) - Хүн амын жилийн дундаж тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт 2004

Мэдээллийн задаргаа: Улсын түвшин, бүс, аймаг, нийслэлээр тооцох боломжтой

Мэдээллийн тархаалт: ҮСХ-ны Статистикийн эмхтгэл

IV. ХАВСРАЛТ

1. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Эхийн эрүүл мэнд

1.1. Жирэмсний хяналтын хувь

Тухайн оны жилийн эцсийн байдлаар шинээр Жирэмсний хяналтанд хамрагдсан 52 015 жирэмсэн эмэгтэй, нийт 77 035 жирэмсэн эмэгтэй бүртгэгдсэн байсан гэвэл жирэмсний хяналтын хувийг дараахь байдлаар тооцно.

$$ЖХХ = \frac{ЖЭ_{ХХ}}{ЖЭ} * 100 = \frac{52015}{77035} * 100 = 67.5$$

Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 67.5 хувь нь жирэмсний хяналтанд хамрагдсан байна.

1.2. Зургаа ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Жилийн эцсийн байдлаар жирэмсний хяналтанд 6 ба түүнээс дээш удаа 38 938 эмэгтэйчүүд хамрагдсан, жирэмсний хяналтанд байж төрсөн нийт эмэгтэйчүүдийн тоо 45562 байгаа гэвэл 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$ЖЭХ_{(ХХЭ)} = \frac{ЖЭТ_{(ХХ)}}{ТЭ} * 100 = \frac{38938}{45562} * 100 = 85.5$$

Жирэмсний хяналтанд байж төрсөн нийт эмэгтэйчүүдийн 85.5 хувь нь 6 ба түүнээс дээш удаа жирэмсний хяналтанд хамрагдсан.

1.3. Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь

Тухайн оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн тоо 63 450, нийт төрөлт 65 451 байгаа гэвэл эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувийг дараахь байдлаар тооцно.

$$ЭТХ_{(эма)} = \frac{ЭТТ_{(эма)}}{НТ} * 100 = \frac{63450}{65451} * 100 = 96.9$$

Нийт төрөлтийн 96.9 хувийг эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан байна.

1.4. Эхийн эндэгдлийн түвшин (ЭЭТ)

Тухайн онд 31 эх эндсэн, нөхөн үржихүйн насны эмэгтэй 777 705 байсан гэвэл 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$ЭЭТ = \frac{ЭЭ}{ТНЭ_{(15-49 \text{ насны})}} * 100\ 000 = \frac{31}{777705} * 100\ 000 = 3.9$$

Нөхөн үржихүйн насны (15-49 насны) 100 000 эмэгтэй тутмын 4 нь жирэмсэн, төрөх, төрсний дараахь үеийн хүндрэлээс шалтгаалж нас барсан.

1.5. Эхийн эндэгдлийн харьцаа (ЭЭХ)

Тухайн оны жилийн эцсийн байдлаар жирэмсэн буюу жирэмсний дараахь, мөн хүүхэд төрүүлэх үеийн хүндрэлээс хамаарч 31 эх эндсэн. 63 768 амьд төрөлт байсан гэвэл 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцааг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭЭХ} = \frac{\text{ЭЭ}}{\text{АТ}} * 100\ 000 = \frac{31}{63768} * 100\ 000 = 48.6$$

Тухайн оны байдлаар Жирэмсэн буюу жирэмсний дараахь, мөн хүүхэд төрүүлэх үеийн хүндрэлээс хамаарч 100 000 амьд төрөлт тутамд 49 эх эндсэн байгааг харуулж байна.

1.6. Үр хөндөлтийн харьцаа

Тухайн жилд 10 688 үр хөндөлт бүртгэгдсэн, нийт амьд төрөлтийн тоо 63 768 байгаа гэвэл үр хөндөлтийн харьцааг дараахь байдлаар тооцно.

$$\text{ҮХХ} = \frac{\text{ҮХ}}{\text{АТ}} * 1000 = \frac{10688}{63768} * 1000 = 167.6$$

Энэ нь тухайн оны жилийн эцсийн байдлаар 1 000 амьд төрөлтөд 168 үр хөндөлт ногдож байна.

1.7. Үр хөндөлтийн тусгай коэффициент

Тухайн жилд 10 688 үр хөндөлт бүртгэгдсэн байгаагийн нөхөн үржихүйн насны (15-49 насны) эмэгтэйчүүдийн тоо 777 705 байна гэвэл үр хөндөлтийн харьцааг дараахь байдлаар тооцно.

$$\text{ҮХТК}_{(\text{тусгай})} = \frac{\text{ҮХ}}{\text{НЭ}_{(15-49)}} * 1000 = \frac{10688}{777705} * 1000 = 13.7$$

Тухайн жилд нөхөн үржихүйн насны (15-49 насны) 1 000 эмэгтэй тутмын 14 нь үр хөндүүлсэн байна.

1.8. Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн аргын хэрэглээний хувь

Тухайн жилд Нөхөн үржихүйн насны нийт 777 705 эмэгтэй байгаагаас 391 435 эмэгтэй жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн аргын аль нэгийг хэрэглэдэг бол жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн орчин үеийн аргын хэрэглээний хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЖАХ} = \frac{\text{ЖАХ}_{(15-49 \text{ насны})}}{\text{НЭ}_{(15-49 \text{ насны})}} * 100 = \frac{391435}{777705} * 100 = 50.3$$

Тухайн онд орчин үеийн ЖСАХ-ийн хэрэглээний хувь 50.3 байна.

- Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд

1.9. Нярайн эндэгдлийн түвшин

Тухайн оны жилийн эцсийн байдлаар нийт амьд төрөлтийн тоо 63 768, 0-28 хоногтойдоо эндсэн хүүхдийн тоо 806 байсан гэвэл нярайн эндэгдлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$ЭТ_{(нярайн)} = \frac{ЭХТ_{(28\text{ хоног})}}{АТ} * 1000 = \frac{806}{63768} * 1000 = 12.6$$

Нярайн эндэгдлийн түвшин 12.6 байгаа нь 1 000 амьд төрсөн хүүхэд тутмын 13 нь 0-28 хоногтойдоо эндэж байгааг харуулж байна.

1.10. Нялхсын эндэгдлийн түвшин

Тухайн оны жилийн эцсийн байдлаар нийт амьд төрөлтийн тоо 63 768, 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 1 240 байсан гэвэл нялхсын эндэгдлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$ЭТ_{(нялхсын)} = \frac{ЭХТ_{(1\text{ хүртэлх})}}{АТ} * 1000 = \frac{1240}{63768} * 1000 = 19.4$$

Нялхсын эндэгдлийн түвшин 19.4 байгаа нь 1 000 амьд төрсөн хүүхэд тутмын 19 нь 1 хүртэлх насандаа эндэж байгааг харуулж байна.

1.11. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Тухайн оны жилийн эцсийн байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 546, нийт амьд төрөлтийн тоо 63 768 байсан гэвэл 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$ЭТ_{(5\text{ хүртэлх})} = \frac{ЭХТ_{(5\text{ хүртэлх})}}{АТ} * 1000 = \frac{1546}{63768} * 1000 = 24.2$$

Тухайн оны байдлаар 1 000 амьд төрөлт тутамд 5 хүртэлх насны 24 хүүхэд эндсэн байна.

1.12. Зөвхөн хөхөөр хооллодог 0-6 сартай хүүхдийн эзлэх хувь

Үүнээс зөвхөн хөхөөр хооллодог 0-6 сартай хүүхдийн тоо 229, 0-6 сартай нийт хүүхдийн тоо 400 байна гэвэл зөвхөн хөхөөр хооллодог 0-6 сартай хүүхдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$ЗХХ_{(0-6\text{ сар})} = \frac{ХХТ_{(0-6\text{ сар})}}{ХТ_{(0-6\text{ сар})}} * 100 = \frac{229}{400} * 100 = 57.3$$

0-6 сартай хүүхдүүдийн 57.3 хувь нь зөвхөн эхийн сүүгээр хооллосон байна.

1.13. Нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь

Зөвхөн хөхөөр хооллодог 1 хүртэлх насны хүүхдийн тоо 706, нэг хүртэлх насны нийт хүүхдийн тоо 775 байна гэвэл нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$XXX_{(1 \text{ нас хүртэлх})} = \frac{ХХТ_{(1 \text{ хүртэлх})}}{ХТ_{(1 \text{ хүртэлх})}} * 100 = \frac{706}{775} * 100 = 91.1$$

Нэг хүртэлх насны хүн амын 91.1 хувь нь нэг нас хүртлээ үргэлжлүүлэн хөхөөр хооллож байна.

1.14 Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувь

Нэг хүртэлх насны хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн тоо 55130, нэг хүртэлх насны хүүхэдтэй нийт эмэгтэйчүүдийн тоо 64580 байсан гэвэл хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувийг дараах байдлаар тооцно.

$$ХХЭ_{(хувь)} = \frac{ХА_{(хх)}^{эм}}{ХА_{(хх)}^{эм}} * 100 = \frac{55130}{64580} * 100 = 85.4$$

Хүүхдээ хөхөөр хооллож байгаа эмэгтэйчүүдийн хувь 85.4 гарсан нь нэг хүртлэх настай 100 эмэгтэй тутмын 85 нь хүүхдээ хөхөөрөө хооллож байгааг харуулж байна.

1.15. Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь

5 хүртэлх насны (тухайн насны хүүхдийн биеийн жин нь стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур) дунд хэлбэрийн тураалтай хүүхдийн тоо 205, 5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо 3 252 байгаа гэвэл тураалтай 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$ТЭХ_{(5 \text{ хүртэлх})} = \frac{ТХТ_{(5 \text{ хүртэлх})}}{ХТ_{(5 \text{ хүртэлх})}} * 100 = \frac{205}{3252} * 100 = 6.3$$

Тав хүртэлх насны хүүхдүүдийн 6 хувь нь дунд хэлбэрийн тураалтай байна.

1.16. Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь

5 хүртэлх насны (тухайн насны хүүхдийн биеийн өндөр нь стандарт өндрийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур) дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой хүүхдийн тоо 681, 5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо 3 252 байгаа гэвэл 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$ӨХХ_{(5 \text{ хүртэлх})} = \frac{ӨХТ_{(5 \text{ хүртэлх})}}{ХТ_{(5 \text{ хүртэлх})}} * 100 = \frac{681}{3252} * 100 = 20.9$$

Тав хүртэлх насны хүүхдүүдийн 21 хувь нь өсөлтийн дунд хэлбэрийн хоцролттой байна.

1.17. Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь

5 хүртэлх насны (тухайн өндөрт байвал зохих биеийн жин нь стандарт жингийн голчоос 2 стандарт хазайлтаар доогуур) дунд хэлбэрийн туранхай хүүхдийн тоо 70, тав хүртэлх насны нийт хүүхдийн тоо 3 252 байгаа гэвэл 5 хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ТурХХ}_{(5 \text{ хүртэлх})} = \frac{\text{ТХТ}_{5 \text{ хүртэлх}}}{\text{ХТ}_{5 \text{ хүртэлх}}} * 100 = \frac{70}{3252} * 100 = 2.2$$

Тав хүртэлх насны хүүхдүүдийн 2 хувь нь дунд хэлбэрийн туранхай хүүхдүүд байна.

1.18. Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент

Тухайн оны жилийн эцсийн байдлаар өсвөр насны жирэмсэн 2 680 охид, өсвөр насны нийт охидын тоо 155 376 байгаа гэвэл өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициентийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ОЖК}_{(o.n)} = \frac{\text{ЖОТ}_{(o.n)}}{\text{ОТ}_{(o.n)}} * 1000 = \frac{2680}{155376} * 1000 = 17.2$$

Өсвөр насны 1 000 охид тутмын 17 нь жирэмсэн байна.

1.19. Өсвөр насны охидын жирэмслэлтийн хувь

Тухайн оны жилийн эцсийн байдлаар өсвөр насны жирэмсэн 2 680 охид, нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо 77 035 байгаа гэвэл өсвөр насны охидын жирэмслэлтийн хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ОЖХ}_{(o.n)} = \frac{\text{ЖОТ}_{(o.n)}}{\text{ЖЭ}} * 100 = \frac{2680}{77035} * 100 = 3.5$$

Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 3.5 хувь нь өсвөр насны охид байна.

1.20. Өсвөр насны охидын төрөлтийн коэффициент

Тухайн оны жилийн эцсийн байдлаар өсвөр насны 2 654 охин төрсөн, өсвөр насны нийт охидын тоо 155 376 байгаа гэвэл өсвөр насны охидын төрөлтийн коэффициентийг дараахь байдлаар олно.

$$\text{ОТК}_{(o.n)} = \frac{\text{ОТТ}_{(o.n)}}{\text{ОТ}_{(o.n)}} * 1000 = \frac{2654}{155376} * 1000 = 17.1$$

Тухайн онд өсвөр насны 1 000 охид тутмын 17 нь хүүхэд төрүүлсэн байгааг харуулж байна.

1.21. Өсвөр насны охидын төрөлтийн хувь

Тухайн оны жилийн эцсийн байдлаар өсвөр насны охидын төрөлтийн тоо 2 654, нийт төрөлтийн тоо 65 451 байгаа гэвэл өсвөр насныхны төрөлтийн хувийг дараахь байдлаар тооцно.

$$OTX_{(o.n)} = \frac{OTT_{(o.n)}}{HT} * 100 = \frac{2654}{65451} * 100 = 4.1$$

Тухайн онд нийт төрөлтийн 4.1 хувийг өсвөр насны охидын төрөлт эзэлж байна.

2. ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ

2.1. Өвчлөлийн түвшин

Тухайн онд 27 төрлийн цочмог халдварт өвчний нийт 36221 тохиолдол гарсан, хүн амын жилийн дундаж тоо 2659347 байсан гэвэл өвчлөлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$\Theta T = \frac{\text{ШБӨ}}{ХА_{(дун)}} * 10\ 000 = \frac{36221}{2659347} * 10000 = 136.2$$

Тухайн онд 10 000 хүн амд ногдох нийт халдварт өвчний өвчлөлийн 136 тохиолдол гарсан байна.

2.2. Амбулаторийн өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тухайн оны байдлаар эмнэлгийн үзлэг, үйлчилгээгээр үйлчлүүлсэн (бүртгэгдсэн) амьсгалын эрхтэн тогтолцооны өвчний тохиолдлын тоо 196 586, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин 189 324, шээс бэлгэсийн тогтолцооны өвчнүүд 180 230, бусад 174 235, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 130 216, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчний үр дагавар 94 854, жирэмслэх, төрөх, төрсний дараахь үе 76 663, мэдрэлийн тогтолцооны өвчин 60 514, халдварт ба шимэгчит зарим өвчин 38 647, яс булчингийн тогтолцоо, холбох нэхдэсийн өвчин 32 851, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байсан гэвэл амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгааныг дараахь байдлаар тооцно.

$$A\Theta\text{Ш}_{(т.10)} = \frac{\Theta TT_{(б.а.т)}}{ХА_{(дун)}} * 10000 = \frac{196586}{2659347} * 10000 = 739.2$$

Тухайн оны жилийн эцэст (ӨОУА-10-ын дагуу) амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан дотор зонхилж байгаа өвчнүүдийг 10000 хүн амд ногдох түвшингээр авч үзвэл амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 739.2, хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин 711.9, шээс бэлгэсийн тогтолцооны өвчнүүд 677.7, бусад 655.2, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 489.7, бэртэл хордлого, гадны шалтгаант өвчний үр дагавар 359.7, жирэмслэх, төрөх, төрсний дараахь үе 288.3, мэдрэлийн тогтолцооны өвчин 227.6, халдварт ба шимэгчит зарим өвчин 145.3, яс булчингийн тогтолцоо, холбох нэхдэсийн өвчин 123.5 байна.

2.3. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвчлөл, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тухайн жилийн байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн (стационарит бүртгэгдсэн) шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 93 431, хоол шингээх эрхтний өвчин 88 592, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 80 130, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 78981, мэдрэлийн тогтолцооны өвчин 38 251, халдварт ба шимэгч зарим өвчин 26 437, бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагаварт өвчин 26 152, яс булчин холбох нэхдэсийн өвчин 22 152, арьс ба халимны өвчин 11 477, сэтгэцийн ба аягийн эмгэг 15 026, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байсан гэвэл эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн (стационарит бүртгэгдсэн) өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгааныг дараахь байдлаар тооцно.

$$CӨШ_{(т.10)} = \frac{СТТ_{(Б.С.Т)}}{ХА_{(дун)}} * 10000 = \frac{93431}{2659347} * 10000 = 351.3$$

Тухайн жилийн байдлаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн (ӨОУА-10-ын дагуу) өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгаан дотор зонхилж байгаа өвчнүүдийг 10 000 хүн амд ногдох түвшингээр авч үзвэл шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 351.3, хоол шингээх эрхтний өвчин 333.1, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 301.3, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 297.0, мэдрэлийн тогтолцооны өвчин 143.8, халдварт ба шимэгч зарим өвчин 99.4, бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагаварт өвчин 98.3, яс булчин холбох нэхдэсийн өвчин 83.3, сэтгэцийн ба аягийн эмгэг 43.2, арьс ба халимны өвчин 56.5 байна.

2.4. Өвчний тархалтын түвшин

Тухайн жилийн байдлаар сүрьеэгээр өвчилсөн нийт хүний тоо 2 201, жилийн эцсийн хүн амын тоо 2 745 639 байсан гэвэл тархалтын түвшинг дараахь байдлаар тооцно.

$$ӨТТ = \frac{ӨХТ_{(т.ө)}}{ХА_{(эц)}} * 100\ 000 = \frac{2201}{2745639} * 100\ 000 = 8.0$$

Тухайн жилд 100 000 хүн ам тутмын 8 нь сүрьеэ өвчнөөр өвчилсөн байгааг харуулж байна.

2.5. Өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшин

Тухайн жилд хорт хавдраар өвчилж нас барсан хүний тоо 2 899, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байсан гэвэл өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшинг дараахь байдлаар тооцно.

$$НБТ_{(ӨА)} = \frac{НБХ_{(т.ө)}}{ХА_{(дун)}} * 10\ 000 = \frac{2899}{2659347} * 10000 = 10.9$$

Энэ нь 10 000 хүн амд ногдох хорт хавдрын өвчний ангиллаар тооцсон нас баралтын түвшин 10.9 байгааг харуулж байна.

2.6. Хүн амын нас баралт, тэргүүлэх 10 шалтгаанаар

Тухайн оны байдлаар хүн амын нас баралтын шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 5 461, хавдар 3 137, бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагаварт өвчин 2482, хоол шингээх эрхтний өвчин 1 402, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин 637, төрөх тойрны (перинаталь) үед үүсэх оёг 644, халдварт ба шимэгч зарим өвчин 418, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин 327, мэдрэлийн тогтолцооны өвчин 244, дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд 100, хүн амын жилийн дундаж тоо 2 659 347 байсан гэвэл хүн амын нас баралтын өвчлөлийн тэргүүлэх 10 шалтгааныг дараахь байдлаар тооцно.

$$\text{НБШ}_{(т.10)} = \frac{\text{НТТ}_{(т.10)}}{\text{ХА}_{(дун)}} * 10\,000 = \frac{5461}{2659347} * 10\,000 = 20.5$$

Тухайн оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 10 шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин (10000 хүн амд 20.5), хавдар (10000 хүн амд 11.8), бэртэл, хордлого ба бусад зарим гадны шалтгааны үр дагаварт өвчин (10000 хүн амд 9.3), хоол шингээх эрхтний өвчин (10000 хүн амд 5.3), амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин (10000 хүн амд 2.4), төрөх тойрны (перинаталь) үед үүсэх оёг (10000 хүн амд 2.4), халдварт ба шимэгч зарим өвчин (10000 хүн амд 1.6), шээс бэлгэсийн тогтолцооны өвчин (10000 хүн амд 1.2), мэдрэлийн тогтолцооны өвчин (10000 хүн амд 0.9), дотоод шүүрэл тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд (10000 хүн амд 0.4) тус тус орсон байна.

2.7. Эмнэлэгт нас баралтын хувь

Тухайн жилд эмнэлэгт нас барсан хүний тоо 3 740, нийт нас баралтын тоо 15 665 байсан гэж үзвэл эмнэлэгт нас барсан хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭНБ}_x = \frac{\text{НБХТ}_x}{\text{НБТ}} * 100 = \frac{3740}{15665} * 100 = 23.9$$

Нийт хүн амын нас баралтын 23.9 хувь нь эмнэлэгт нас барсан байна.

2.8. Эмнэлгийн нас баралтын хувь

Тухайн жилд эмнэлэгт нас барсан хүний тоо 3740, нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 598701 байсан гэж үзвэл эмнэлгийн нас баралтын хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{НБХ}_y = \frac{\text{НБХТ}_y}{\text{ХЭТ}} * 100 = \frac{3740}{598701} * 100 = 0.6$$

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 0.6 хувь нь эмнэлэгт нас барсан байгааг харуулж байна.

2.9. Хоног болоогүй нас баралтын хувь

Тухайн жилд эмнэлэгт хоног болоогүй нас барсан тохиолдол 857, эмнэлэгт нас барсан нийт тохиолдол 3740 байсан гэвэл хоног болоогүй нас баралтын хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{НБХ}_{\text{ХБ}} = \frac{\text{НБТ}}{\text{НБТ}_3} * 100 = \frac{857}{3740} * 100 = 22.9$$

Эмнэлэгт нас барсан нийт тохиолдлын 22.9 хувь нь хоног болоогүй нас барсан байна.

3. БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан хувь

Заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн тоо 23 532, нэг хүртэлх насны нийт хүүхдийн тоо 23 879 байгаа гэвэл заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ДХХ}_{\text{ЗХ}} = \frac{\text{ДХХ}_{1\text{х}}}{\text{ХТ}_{1\text{х}}} * 100 = \frac{23532}{23879} * 100 = 98.5$$

Нэг хүртэлх насны хүн амын 98.5 хувь нь заавал хийх дархлаажуулалтанд хамрагдсан байна.

3.2 Нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувь

Идэвхтэй хяналтанд хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн тоо 43770, 1 хүртэлх насны нийт хүүхдийн тоо 43 982 байгаа гэвэл нэг хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ИХХ}_{1\text{хүртэлх}} = \frac{\text{ИХХТ}_{1\text{хүртэлх}}}{\text{ХТ}_{1\text{хүртэлх}}} * 100 = \frac{43770}{43982} * 100 = 99.5$$

Жилийн эцсийн байдлаар 1 хүртэлх насны нийт хүүхдийн 99.5 хувь нь идэвхтэй хяналтанд хамрагдсан байна.

3.3. 1-5 хүртэлх насны идэвхтэй хяналтын хувь

Идэвхтэй хяналтанд хамрагдсан 1-5 хүртэлх насны хүүхдийн тоо 171 621, 1-5 хүртэлх насны нийт хүүхдийн тоо 182 122 байгаа гэвэл нэгээс тав хүртэлх насны идэвхтэй хяналтын хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ИХХ}_{(1-5)} = \frac{\text{ИХХТ}_{(1-5)}}{\text{ХТ}_{(1-5)}} * 100 = \frac{171621}{182122} * 100 = 94.2$$

Тухайн жилд 1-5 хүртэлх насны хүүхдийн 94.2 хувь нь идэвхтэй хяналтанд хамрагдсан байна.

3.4. Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь

Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн тоо 5082, нийт өрхийн тоо 6113 гэвэл иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$\Theta X_{(\text{ИДХ})} = \frac{\Theta T_{(\text{ИДХ})}}{\Theta T} * 100 = \frac{5082}{6113} * 100 = 83.1$$

Нийт өрхийн 83.1 хувь нь иоджуулсан давс хэрэглэж байна.

3.5. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт

Судалгаагаар 5-6 настай шүд цоорох өвчтэй хүүхдийн тоо 1 178 харин 5-6 насны нийт хүүхдийн тоо 1 489 гэвэл 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг дараах байдлаар тооцно.

$$\Theta T_{\text{шц}(5-6)} = \frac{\Theta X T_{\text{шц}(5-6)}}{X T_{\text{шц}(5-6)}} = \frac{1178}{1489} * 100 = 89.1$$

5-6 настай хүүхдийн 89.1 хувь нь шүд цоорох өвчтэй байна.

3.6. 10 000 хүн амд ногдох эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо

Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 638 400, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 гэвэл эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоог дараахь байдлаар тооцно.

$$X \Theta T_{(10\ 000)} = \frac{X \Theta T}{X A_{(\text{дун})}} * 10\ 000 = \frac{638400}{2659347} * 10\ 000 = 2400.6$$

Тухайн оны байдлаар 10 000 хүн ам тутмын 2 400 нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна.

3.7. 10000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо

Эмнэлгийн нийт орны тоо 18 078, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байгаа гэвэл 10 000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоог дараахь байдлаар тооцно.

$$\Theta O T_{(10\ 000)} = \frac{H O T_{(\text{эа})}}{X A_{(\text{дун})}} * 10\ 000 = \frac{18078}{2659347} * 10\ 000 = 70.0$$

Тухайн онд 10 000 хүн амд ногдох эмнэлгийн орны тоо 70 байна.

3.8. Орны эргэлт

Нийт эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо 638 400, жилийн дундаж эмнэлгийн орны тоо 18 005 байгаа гэвэл орны эргэлтийн тоог дараахь байдлаар тооцно.

$$\Theta O \Theta = \frac{\Theta O T}{J \text{Д} O} = \frac{638400}{18005} = 35.5$$

Тухайн онд эмнэлгийн нэг орыг 36 удаа өвчтөн ашигласан байна.

3.9. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо

Тухайн жилд эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоо 37 952, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байгаа гэвэл 10 000 хүн амд ногдох эрүүл мэндийн салбарын нийт ажиллагчдын тоог дараахь байдлаар тооцно.

$$AT_{(10\ 000\ эмс)} = \frac{AT_{(эмс)}}{ХА_{(дун)}} * 10\ 000 = \frac{37952}{2659347} * 10\ 000 = 142.7$$

Тухайн оны байдлаар 10 000 хүн амд эрүүл мэндийн салбарын 143 ажиллагч ногдож байна.

3.10. Нэг их эмчид ногдох хүн амын тоо

Тухайн оны жилийн дундаж хүн амын тоо 2 659 347, нийт их эмчийн тоо 7 584 байгаа гэвэл нэг их эмчид ногдох хүн амын тоог дараахь байдлаар тооцно.

$$ИСТ = \frac{ИСТ_{(н\ййт)}}{ХА_{(дун)}} * 10\ 000 = \frac{7584}{2659347} * 10\ 000 = 28.5$$

Тухайн оны байдлаар нэг их эмчид 351 хүн ногдож байгааг харуулж байна.

3.11 Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ/ДОХ-ын тархалт /хувь/

Тухайн жилд ХДХВ-ийн халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо 2, нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо 46982 байгаа гэж үзвэл жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ/ДОХ-ын халдварын тархалтыг дараах байдлаар тооцно.

$$ТХ_{ХДХВ/ДОХ}^{ж.э} = \frac{ЖЭТ_{(ХДХВ/ДОХ)}}{ЖЭ} * 100 = \frac{2}{46982} * 100 = 0.004$$

Тухайн онд нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 0.004 хувь буюу 1000 эмэгтэй тутмын 1 нь ХДХВ/ДОХ-ын халдвартай байна.

3.12. 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт /хувь/

Тухайн жилд ХДХВ/ДОХ-ын халдвар авсан 15-24 насны залуучуудын тоо 3, 15-24 насны хүн амын тоо 958652 байгаа гэж үзвэл 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ/ДОХ-ын халдварын тархалтыг дараахь байдлаар тооцно.

$$ТХ_{ХДХВ/ДОХ}^{15-24} = \frac{ХА_{ХДХВ/ДОХ}^{15-24}}{ХА_{(15-24)}} * 100 = \frac{3}{958652} * 100 = 0.0003$$

Тухайн онд 15-24 насны 10 000 залуучуудын 0.0003 хувь нь ХДХВ/ДОХ-ын халдвартай байна.

3.13. ХДХВ/ДОХ-ын нас баралтын түвшин /100 000 хүн тутамд/

Тухайн жилд ХДХВ/ДОХ-оор нас барсан хүний тоо 2, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байгаа гэж үзвэл ХДХВ/ДОХ-ын улмаас нас барсан хүний тоог дараахь байдлаар тооцно.

$$НБТ_{ХДХВ/ДОХ} = \frac{НБХТ_{(ХДХВ/ДОХ)}}{ХА_{(дун)}} * 100\ 000 = \frac{2}{2659347} * 100\ 000 = 0.08$$

Тухайн жилд 100 000 хүн тутмын 0.08 нь ХДХВ/ДОХ-ын улмаас нас барсан байна.

3.14. Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт /100 000 хүн тутамд/

Тухайн жилд сүрьеэ өвчнөөс шалтгаалж нас барсан хүний тоо 1 211, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байгаа гэж үзвэл сүрьеэгээс шалтгаалсан нас баралтын тоог дараахь байдлаар тооцно.

$$НБТ_{(с.100\ 000)} = \frac{НБ_{(с)}}{ХА_{(дун)}} * 100\ 000 = \frac{1211}{2659347} * 100\ 000 = 45.5$$

Тухайн онд 100 000 хүн тутмын 46 нь сүрьеэ өвчний улмаас нас барсан байна.

3.15. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100 000 хүн тутамд/

Тухайн жилд шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоо 1 238, жилийн дундаж хүн амын тоо 2 659 347 байгаа гэж үзвэл 100 000 хүн тутамд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшинг дараахь байдлаар тооцно.

$$\Theta T_{(с.100\ 000)} = \frac{СТ_{(с)}}{ХА_{(дун)}} * 100\ 000 = \frac{1238}{2659347} * 100\ 000 = 46.6$$

Тухайн онд 100 000 хүн тутмын 47 нь сүрьеэ өвчнөөр өвчилсөн байна.

3.16. Сүрьеэ өвчний тархалтын түвшин /100 000 хүн тутамд/

Тухайн жилд сүрьеэтэй нийт өвчтний тоо 4 231, жилийн эцсийн хүн амын тоо 2 745 639 байгаа гэж үзвэл сүрьеэ өвчний тархалтын түвшинг дараахь байдлаар тооцно.

$$\Theta TT_{(с.100\ 000)} = \frac{\Theta T_{(с)}}{ХА_{(эц)}} * 100\ 000 = \frac{4231}{2745639} * 100\ 000 = 154.1$$

Тухайн жилд 100 000 хүн тутмын 154.1 нь сүрьеэгийн өвчтэй байна.

3.17. Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж эмчилсэн тохиолдлын хувь

Тухайн жилд Шууд Хяналттай Богино Хугацааны Эмчилгээний (ШХБХЭ/DOTS) дунд бүрэн эдгэрсэн өвчтөний тоо 3 245 тайлангийн өмнөх жилд (12-15 сарын өмнө) ШХБХЭ-нд хамрагдсан түрхэц нь эерэг байгаа сүрьеэгийн тохиолдлын тоог 3 146 байгаа гэж үзвэл оношлогоо эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж эмчилсэн тохиолдлын хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭТХ}_{(\text{COYC})} = \frac{\text{ЭӨТ}}{\text{ТТ}_{(\text{C})}} * 100 = \frac{3245}{3146} * 100 = 103.1$$

Тухайн жилд оношлогоо эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж эмчилсэн тохиолдлын хувь 3.1 байна.

3.18. Нэг хүний эмнэлгээр үйлчлүүлсэн жилийн дундаж тоо

Тухайн жилд амбулаторийн нийт үзлэгийн тоо 159 689, жилийн дундаж хүн амын тоо 659 347 гэвэл нэг хүний эмнэлгээр үйлчлүүлсэн жилийн дундаж тоог дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭҮДТ} = \frac{\text{АҮТ}}{\text{ХА}_{(\text{дун})}} = \frac{159689}{2659347} = 0.06$$

Тухайн жилд улсын төсөв болон даатгалын сангаас нэг иргэн дунджаар 0.06 удаа эмнэлэгт хандан үйлчлүүлж байна.

4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭДИЙН ЗАСАГ

4.1. Эрүүл мэндийн нийт зардал

Тухайн жилд улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас 289 859.5 сая төгрөг, хувь хүний өөрөө төлөх зардал 15 893.5 сая төгрөг байсан гэвэл эрүүл мэндийн нийт зардлыг дараахь байдлаар тооцно.

$$\text{НЗ}_{(\text{эм})} = \text{ЗЗ}_{(\text{ут,дс})} + \text{ХЗ} = 289859.5 + 15893.5 = 305753$$

Тухайн жилд улсын төсөв болон даатгалын сангаас эрүүл мэндийн салбарт нийт 305 753 сая төгрөг зарцуулсан байна.

4.2. Улсын төсөвт эрүүл мэндийн зардлын эзлэх хувь

Тухайн жилд эрүүл мэндийн салбарт улсын төсвөөс зарцуулсан нийт зардал 213 122.6 сая төгрөг, улсын нийт төсөв 2 462 046.6 сая төгрөг байсан гэж үзвэл улсын төсөвт эрүүл мэндийн салбарын эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭМЗЭХ}_{(\text{төсөв})} = \frac{\text{ЭМЗЗ}}{\text{УТ}} * 100 = \frac{213122.6}{2462046.6} * 100 = 8.7$$

Тухайн жилд улсын төсвийн зардлын 8.7 хувийг эрүүл мэндийн зардал эзэлж байна.

4.3. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь

Тухайн жилд эрүүл мэндийн нийт зардал 213 122.6 сая төгрөг, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 1 895 125 сая төгрөг байсан гэж үзвэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн зардлын эзлэх хувийг дараахь байдлаар тооцно.

$$\text{ЭМЗЭХ}_{(\text{ДНБ})} = \frac{\text{ЭМНЗ}}{\text{ДНБ}} * 100 = \frac{213122.6}{1895125} * 100 = 11.2$$

Дотоодын нийт бүтээгдэхүүний 11.2 хувийг эрүүл мэндийн нийт зардал эзэлж байна.

4.4. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал

Тухайн жилд эрүүл мэндэд зарцуулсан нийт зардал 213 122.6 сая төгрөг, хүн амын жилийн дундаж тоо 2 659 347 байна гэвэл нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлыг дараах байдлаар тооцно.

$$\text{ЭМЗ}_{(1 \text{ хүнд})} = \frac{\text{ЭМНЗ}}{\text{ХА}_{(\text{дун})}} = \frac{213122600000}{2659347} = 80140$$

Тухайн жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 80140 төгрөг байна.

V. АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. “Статистикийн эмхтгэл”, ҮСХ, 2008 он
2. ДЭМБ-ын 2006 оны эмхтгэл
3. “Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд” ЭМЯ, 2004 он
4. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал” ҮСХ, 2009 он
5. “Хүн ам зүйн ойлголт, тодорхойлолтууд”, Хүн ам зүйн үндсэн асуудлууд” МУИС-ХАССТ, 2006 он
6. “Хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэр томъёоны тайлбар толь”, НҮБ-ын ХАС, 2002 он
7. “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн талаарх гарын авлага”, АНДОЭЗНК, НҮБ, 2003 он
8. “The Methods and Materials of Demography”, Henry S. Shryock, Jacob S. Siegel
9. “Техникийн тайлан”¹ 461, ДЭМБ, Женев, 1970 он
10. “Өвчлөл болон эрүүл мэндийн асуудлуудтай холбоотой олон улсын статистикийн ангилал” 10 дахь хэвлэл, ДЭМБ, Женев, 1992 он
11. “Олон улсын статистикийн ангилал”, ДЭМБ Женев, 1992 он
12. “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого” асуулгын үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтууд”. ҮСХ, 2009 он